



НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 3/44

Улаанбаатар хот

Даргын үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/409 дүгээр захирамж, Газрын дотоод журмын 2.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны А/300 дугаар тушаалын дагуу газрын дарга албан томилолтоор гадаадад ажиллах болсон тул 2017 оны 11 дүгээр сарын 20-30-ны өдрүүдэд газрын даргын үүрэгт ажлыг Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга /Г.Ганзориг/-д түр орлон гүйцэтгүүлсүгэй.

2. Ажил эрчимжүүлэх үүрэг даалгаврыг хавсралтаар баталсугай.

3. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангуулж, үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавин хэрэгжилтийг тооцож ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга /Г.Ганзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.БАТХҮЛЭГ



Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын
даргын дотоот тушаалын хавсралт



АЖИЛ ЭРЧИМЖҮҮЛЭХ ҮҮРЭГ
ДААЛГАВАР

Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс /Г.Ганзориг/-т:

1. Дээд шатны байгууллага /ХХҮЕГ, НИТХ, НЗДТГ гэх мэт/ болон холбогдох газраас зохион байгуулсан шуурхай хурал, зөвлөгөөнд байгууллагыг төлөөлөн оролцох
2. Орлогыг орлуулан тооцох аргачлалын дундын мэдээллийн санд нэвтэрч хэрэгцээт мэдээллийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас авч, гэрээ байгуулан судалгааны ажлыг дуусгах
3. LMIS программын бүртгэлийг эрчимжүүлэх
5. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв” байгуулах ажлыг эрчимжүүлж, явцын талаар тухай бүр мэдээлэх /ажлын хэсэг/
6. Албан хаагчдын цаг ашиглалтад хяналт тавих
7. А/45 дугаар тушаалын /Ажил эрчимжүүлэх тухай/ хэрэгжилтэнд хяналт тавих/

Бодлого төлөвлөлтийн хэлтэс /Г. Гантүшиг/-т:

1. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”, “Цагийн ажлын бирж”-ийн дотоод журам боловсруулж, танилцуулах
2. Ажлын байрны тодорхойлолтыг бэлэн болгох.
3. Цаг үеийн шинжтэй бусад асуудлаар албан хаагчдыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах

Сургалт судалгааны хэлтэс /Ш. Пүрэвдорж/-т:

1. “Цагийн ажлын бирж”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх
2. Цаг үеийн шинжтэй бусад асуудлаар албан хаагчдыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах